



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 55

Чингис хот

Сонгон шалгаруулалтын комисс
томилох тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 10, 19, 20, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмнөдэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Жаргалтхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалттай холбоотой иргэдээс гарсан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Ж.Гантулга	-Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ч.Болормаа	-Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Хүний нөөцийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүн:	С.Бат-Эрдэнэ	-Салбар зөвлөлийн гишүүн, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шударга, ил тод байх, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгон зохион байгуулж, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн онооны жагсаалт, сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлангийн хамт Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комиссын дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР